



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 731

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө ашиглах хугацаа,  
үнийг шинэчлэн тогтоож  
балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Газрын үйлчилгээний албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 49,500,000.00 (дөчин есөн сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий тээврийн хэрэгслийг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Төв-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй

2. Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, “Төв-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Болдбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газрын 2020 оны 12  
дугаар сарын 28 -ны өдрийн 731  
дүгээр тогтоолын хавсралт

**Иргэний нисэхийн ерөнхий газрын /Газрын үйлчилгээний алба/ үндсэн  
хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг цаашид ашиглах жил унийг шинэчлэн тогтоож  
"Төв-АЗЗА" ТӨХК-д балансаас балансад шилжүүлэх үндсэн хөрөнгийн  
жагсаалт**

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглал танд орсон огноо	Балансын, хуримтлагдсан элэгдлийн дүн (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ	Цаашид ашиглах хугацаа
1	Country маркийн, 62-72 УНП улсын дугаартай, автобус, арлын дугаар-KMJHD17PP5C027099	2005/2006	49,500,000.00	8,250,000.00	1 жил
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		49,500,000.00 (дөчин есөн сая таван зуун мянган)	8,250,000.00 (найман сая хоёр зуун тавин мянга)	